



ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/19

Мөрөн сум


Төрийн болон албаны нууцтай танилцах
эрх бүхий албан тушаалтны
жагсаалт батлах тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 4.3.1, 4.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Мөрөн суманд төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журамд заасан эрх, үүргийг танилцуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Хууль, эрх зүйн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Г.Хишигбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Н.НАМЖИЛНОРОВ



Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын
даргын 2026 оны 4 дүгээр сарын 10
өдрийн 19 тушаалын хавсралт

МӨРӨН СУМАНД ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

№	Овог нэр	Албан тушаал	Нууцтай танилцах түвшин	Нууцтай танилцах үндэслэл, Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтны үүрэг	Тайлбар
1	Норовсамбуу Хатанбаатар	Сумын Засаг дарга	Тусгай нөхцөл	ТБАНТХуулийн 21.3.Төрийн болон албаны нууцад хамаарах асуудлыг хянан шалгах зорилгоор тусгайлан эрх олгогдсон хүн тухайн шалгах асуудлын хүрээнд хуулиар танилцуулахыг хориглосноос бусад төрийн болон албаны нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.	Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан
2	Энхболд Балчиндорж	Засаг даргын орлогч	2 дугаар түвшний	ТБАНТХуулийн 20.1.Энэ хуулийн 21 дүгээр зүйлд зааснаас бусад төрийн нууцтай танилцах ажил, албан тушаалд аюулгүй байдлын шалгалтын дүнг үндэслэн тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгосон иргэнийг ажиллуулна.	Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан